

**“ТАВ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

№ 26/2153

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.6 дахь заалт, ТАВ (ХК) Компанийн дүрмийн 10.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “ТАВ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 38 дугаар хороо “ТАВ” ХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

- Компанийн хэлбэрийн өөрчлөлтийг хэлэлцэж батлах,
- Компанийн дүрмийг шинэчлэн батлах
- Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнээр байгуулсугай. Үүнд:

Дарга: Х.Бат-Ирээдүй

Гишүүд: Э.Эрдэнэбилэг

Б.Пүрэвсүрэн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Л.Цогзолмаа

4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст шаардлагатай дараах арга хэмжээг авахыг даалгасугай. Үүнд:

- Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг “Хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн дотор нийтэд мэдээлэх;
- Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх;

- Хурлын мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон “Хөрөнгийн бирж” ХК-д 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн дотор хүргүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичгийг санал авах хуудасны хамт үнэт цаасны брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 06 дугаар сарын 29-ний дотор багтаан хүргүүлэх;
- Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах тогтоолын төсөл, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2026 оны 06 дугаар сарын 29-ны өдрөөс 2026 оны 07 дугаар сарын 24 -ний өдрийг дуустал 09:30–17:00 цагт компанийн байрны хурлын өрөөнд танилцуулж, саналын хуудсаар санал авах.

5. Хурал зарласны дараа хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст зөвшөөрсүгэй. Үүнд:

- Компанийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл;
- Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт;
- Компанийг өөрчлөн байгуулах тухай төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төсөл;
- Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой бусад мэдээлэл.


6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

7. Ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөр тогтоосугай.

8. Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудас хүлээн авах сүүлийн хугацааг 2026 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 12:00 цагт тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.ГАНБОЛД-ыг сонгосугай.

10. Хурлын тооллогын комиссын даргаар Х.Бат-Ирээдүй, гишүүдээр Л.Цогзолмаа, Б.Пүрэвсүрэн томилсугай.



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА**

С.ГАНБОЛД

**“ТАВ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

“ТАВ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2026 оны 06р сарын 19 өдрийн 12 цагт Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг 38-р хороо “ТАВ” ХК-ийн хурлын танхимд 12:00-д эхлэв. Уг хурлаар Хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай төслийг ьтанилцуулж хурлын ирцийн талаарх мэдээг Тооллогын комиссын дарга Х.Бат-Ирээдүй танилцууллаа. Хурлын ирц:

ТУЗ-ийн дарга:
Гишүүд:

С.Ганболд
С.Сэргэлэн
С.Ундармаа
С.Зоригоо
Л.Цогзолмаа
Р.Доржмядаг
Ч.Золзаяа
А.Ишдорж
Х.Бат-Ирээдүй
Ж.Эрдэнэбилэг
Б.Пүрэвсүрэн
Ж.Хатанбаатар нар оролцов.

Уг хурлыг нээж С.Ганболд үг хэлэв.

1. Хурлын ирц 88,4 хувьтай байна. 50 хувиас дээш учраас уг хурал нь хүчин төгөлдөрт тооцогдоно.
2. Өнөөдрийн хурлаар ХК-ний хэлбэр өөрчилөх, бусад асуудлаар хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурал зарлах юм.

Үйл ажиллагааны чиглэл нэмэгдэж, хасагдаагүй хэвийн байгаа.Нүүрс тээврийн ханш маш бага болсон тул ашиггүй ажиллаж байна. Мөн түлш, сэлбэг хэрэгсэл, ашиглалтын зардлын үнэ өссөн.Ашиггүй ажиллах гол эх үүсвэр нь түлш, сэлбэгийн үнэ өссөнтэй холбоотой. Татвар, даатгалын хураамжийн дарамтанд орж өндөр төлж байгааг нуух шаардлагагүй хүн болгон мэдэж байгаа байх.Ажиллах хүчийг цомхотгох,ажлын байрыг багасгах хэрэгтэй болсон.Мөн хувьцаат компани гэсэн хэлбэрийг өөрчилөх тухай олон жилийн өмнөөс яриж байсан. Иймд энэ асуудлыг хэлэлцэхээр цугласан билээ. Нүүрс тээврийн үйл ажиллагаа маань анх боломжийн ашигтай гэж үзэн эхлүүлж байсан. Эрдэнэс таван толгойХК болон Энержи Ресурс ХХК-ийн экспортолж байгаа нүүрсийг тээвэрлэж 2016 онд 3 тээврийн хэрэгсэлтэй эхэлж байсан баГоломт банкнаас өнгөрсөн онуудад зээл авч машины тоог нэмснээр одоогоор10 ш тээврийн хэрэгслээр Таван толгойн уурхайгаас Ганц модны боомт хүртэл тээвэрлэн хүргэх ажлыг гэрээний дагуу гүйцэтгэж байна. Машины тоо өссөнөөр тээврийн орлого маань 2 дахин нэмэгдэж байгаа боловч 2019 оны дэлхийг хамарсан цар тахлаас хамааран ажи ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа хумигдан тээврийн захиалга 70-80 хувь буурч зогсонги шахуу байдалд орсон.Монгол улсын 21 аймаг болон сумдад хүнс,мах тоног төхөөрөмж , тариа буудай, хангамжийн бараануудын хүргэлт,шатахууны тээвэрлэлтийн тоо багасч дотоодын тээвэрлэлт хүртэл багассан.Энэ бүхэнтэй сэлбэг хэрэгсэл, түлшний ханш өсөлт шууд хамааралтай.Мөн нүүрс тээвэрлэлтийн ханш багассантай холбоотойгоор цалин хөлс буурч Өмнөговь аймгийг зорьж ажилд орох

хүмүүсийн тоо багассан. Үйл ажиллагааны талаар ерөнхий мэдээлэл өглөө. Санхүүгийн талаар Л.Цогзолмаа еөрнхийд нь мэдээлэл өгч танилцуулсан. Мөн компаний хэлбэр өөрчилөх 2026 оны 05-р сарын 19-ны өдрийн ээлжит бус хурлын тогтоолын хүчингүй болгох саналтай байна. Товлосон хугацаанд амжаагүй ба дахин хуралдуулах саналтай байна. Мөн гүйцэтгэх захирлын албан тушаалаас С.Ганболдыг чөлөөлж, Р.Доржмядагыг томилох саналтай байна. Хэлбэр өөрчилөхтэй холбоотойгоор компаний хөрөнгө болон бизнесийн үнэлгээ хийлгэх зөвшөөрөлтэй газрыг сонгон хамтран ажиллана.

Хурлын дарга С.Ганболд санал асуулгыг нээлээ.

С.Ундармаа

За асуудлыг ерөнхийд нь ойлголоо. Дахин хуралдаж хэлбэр өөрчилөхийг зөвшөөрч байна. Мөн хууль журмын дагуу бүх процесс явагдах ёстой.

С.Зоригоо

Татгалзах зүйл алга байна.

С.Сэргэлэн

Энэ асуудлаар олон удаа хуралдаж байна. Иймд хуулийн хүрээнд бүх бичиг баримт боловсруулж хийнэ бизээ. Татгалзах зүйлгүй байна.

С.Ганболд

Өөр санал бодол байна уу. Хэрэв байхгүй бол өнөөдрийн хурлыг үүгээр дуусгаж байна. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.



ТУЗ-ийн дарга:

Гишүүд:

С.Ганболд

С.Сэргэлэн

С.Ундармаа

С.Зоригоо

Л.Цогзолмаа

Р.Доржмядаг

Ч.Золзаяа

А.Ишдорж

Х.Бат-Ирээдүй

Ж.Эрдэнэбилэг

Б.Пүрэвсүрэн

Ж.Хатанбаатар